



ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ
АГРОЭКОЛОГИЙН СУРГУУЛЬ

17024 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
11 дүгээр хороо, Зайсан 5, Утас: 7510 7777 243
И-мэйл: agroecology@mul.s.edu.mn
Вэб сайт: www.mul.s.edu.mn

2022.09.15 № 01/232
танай _____ -ны № _____ -т

**Хичээлийн хөтөлбөрт
санал өгөх тухай**

Хичээлийн зорилго, ач холбогдлыг Хот тохижуулалтын загвар, тэдгээрийн олон янз байдал, хот тохижилтод тохиромжтой мод бут сөөг ургуулах арга зүй, мэдлэг чадвар эзэмшүүлэхэд оршино гэж заасан байна. Гэвч лекц, дадлагын хичээлд хот тохижилтын загвар боловсруулах тухай сэдэв, агуулга ороогүй харагдаж байна. Мөн хичээлээр эзэмших чадвар хэсэгт цэцэрлэг, ногоон байгууламжийн талаарх шинжлэх ухааны үндэстэй онол, практикийн гүнзгий мэдлэгтэй, хот байгуулалт, төлөвлөлтийн шаардлага, нормативд заасан хэмжээнд хүрсэн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт бий болгох чиглэлд бие даан ажиллах чадвартай мэргэжилтэн гарах болно гэж бичжээ. Энэ нь хичээлийн хөтөлбөр бус мэргэжлийн хөтөлбөрийн тодорхойлолт маягтай болсон байна. Эдгээрээс харахад Хотын ногоон байгууламж хичээлд зорилго, ач холбогдолдоо тулгуурлан дараах засварыг хийх саналтай байна. Үүнд:

- Хичээлийн агуулгадаа тулгуурлан мэдлэг, ур чадвар, хандлагаа сайжруулах
- Лекцийн хичээлд Ногоон байгууламжийн үндсэн суурь байгалийн материал нь гоёл чимэглэлийн модлог ургамал байдаг бөгөөд 2 цагийн лекцийн хичээл хангалтгүй бөгөөд цагийг нэмэгдүүлэх
- Лекцийн хичээлийг агуулгын хувьд эхлээд цэцэрлэгжүүлэх арга зүй, ангилал, чимэглэлийн ургамлын биологи онцлог, тарих, арчлах зэргээр дараалуулан төлөвлөх
- Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн чимэглэлийн үүрэг гүйцэтгэдэг цэцгийн ургамлын талаарх лекцийн цаг мөн хангалтгүй тул цагийг нэмэгдүүлэх

022803165

- Семинарын хичээлүүдийг гоёл чимэглэлийн ургамлыг ногоон байгууламжид тарих, суулгах, арчлах арга аргачлал, технологид тулгуурлан явуулбал илүү үр дүнтэй болох болно.
- Семинарын хичээлийн Хот цэцэрлэгжүүлэх ажлын зураг төсөл, Улаанбаатар хотын ногоон байгууламжийн үүсэл зэрэг нь тусгай сэдвүүд тул лекцийн хичээлийн агуулгад багтаах боломжтой юм.

Хичээлийн төлөвлөгөөнд санал өгсөн:

АХЛАХ БАГШ



С.ОДОНГЭРЭЛ, Ph.D